



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит 06 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 06 дугаар хуралдаан 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2020 оны 89 тоот тогтоол); “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний нөхцөл, шаардлага”-д өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2020 оны 05 тоот тогтоол); Радио давтамж ашиглан харилцаа холбооны үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээ эрхлэгч (яриа, дата, мессеж) нарын харилцан холболтын чиглэлээр батлагдсан зохицуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийн тухай танилцуулга; Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийг шийдвэрлэсэн тайлангийн танилцуулга (Хорооны 2022 оны жилийн эцэс, 2023 оны 1 дүгээр улирал); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, Дугаар ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай) асуудлыг тус тус хэлэлцэн зохицуулах хорооны 6 тогтоолыг баталж, хуралдааны 1 тэмдэглэлээр холбогдох ажлын хэсэгт удирдамж, чиглэл өгсөн болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 89 тоот тогтоолын хавсралтаар “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам” батлагдаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 4971 дугаарт хянуулсан бүртгүүлсэн ба энэхүү журамд тус хорооны 2022 оны 59 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлтийг оруулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэн мөрдөн ажиллаж байна. Зар сурталчилгааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3-д “Радио, телевизээр түгээх зар сурталчилгаатай холбогдох харилцааг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар зохицуулна”, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т “Радио, телевизээр дамжуулах аливаа хэлбэрийн зар сурталчилгааны хязгаарлалт, хөтөлбөрийн ивээн тэтгэлт, төлбөрт, захиалгат, теле-худалдааны нэвтрүүлгийн талаарх зохицуулалт хийхтэй холбогдсон журмыг Зохицуулах хороо баталж, хэрэгжилтэд хяналт тавина”, 30 дугаар зүйлийн 30.1.8-д буюу Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх үүрэг хэсэгт “радио, телевизийн хөтөлбөрт тавигдах энэ хуулийн 23, 24 дүгээр зүйлд заасан шаардлагын хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх” гэж тус тус хуульчилсан болно. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн өргөн нэвтрүүлгийн бодлого, зохицуулалт болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн баримтлах зарчмын 5.1.7-д “олон нийтийн нийтлэг эрх ашигт нийцсэн, тэнцвэртэй, бодит мэдээ, мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэх” гэж, 5.1.10-д “үндэсний бүтээлийг дэмжин хөгжүүлэх”, Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлагын 2 дугаар зүйлийн 2.1-т заасны дагуу “олон нийтийн нийтлэг эрх ашигт нийцсэн, тэнцвэртэй, бодит, мэдээ, мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэх зарчмыг баримтлан олон

нийтийг соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх чиглэлийг үндсэн үүрэг, зорилго болгон үзэгч, олон нийтийн эрх ашгийг дээдлэн ажиллах үүрэгтэй” гэж тус тус заасан. ХХЗХ нь дээрх хууль, тогтоомжид заасан чиг үүргийн хэрэгжүүлэх, журмын хэрэгжилтийг хангуулах талаар төрийн байгууллага, үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал, зөвлөмжийн хүрээнд телевизээр нэвтрүүлэх эд мөнгөний хонжворт сугалааны нэвтрүүлгийн зохицуулалт; эм, эмнэлгийн хэрэгслийн зар сурталчилгаанд тавих шаардлага; хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрэмд нийцүүлэн хүүхдийн сэтгэхүй, бие махбодод сөргөөр нөлөөлөх хүнсний бүтээгдэхүүнийг хүүхдийн нэвтрүүлгийн хугацаанд сурталчлахгүй байхтай холбоотой хязгаарлалт; зарим тодруулга, дүрэм журмын хоорондын уялдааг хангах зорилгоор 2020 оны 89 тоот тогтоолын хавсралтаар “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналын төслийг боловсруулсан. Хорооны 2023 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар энэхүү журам оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн танилцуулга, тогтоолын төсөл, нөлөөллийн шинжилгээ, уулзалт хэлэлцүүлэг, олон нийтээс санал авахаар нээлттэйгээр байршуулж, ирүүлсэн албан тоот, саналын товчоо судалгааг авч хэлэлцээд, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 51 тоот тогтоолоор ХХЗХ-ны 2020 оны 89 дүгээр тогтоолын хавсралт журмын 1 дүгээр зүйлийн 1.4, 3 дугаар зүйлийн 3.7, 3.18, 3.18¹, 3.20, 3.21, 3.22, 3.23, 3.24, 3.25, 3.26, 4 дүгээр зүйлийн 4.8, 6 дугаар зүйлийн 6.1¹, 6.2 дах хэсэгт оруулах нэмэлт, өөрчлөлтийг (заалт шинээр нэмэх, өөрчлөн найруулах, өөрчлөх, хасах) батлахаар шийдвэрлэв. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2022 оны 59 тоот тогтоолыг хүчингүй болгов. Уг тогтоолыг ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан нэмэлтээр бүртгүүлэхээр албан тоотоор хүргүүлсэн ба туё яамнаас Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4971 бүртгэлтэй 2020 оны 89 тоот тогтоолд оруулсан 2023 оны 51 тоот тогтоолыг хянаж үзээд, энэхүү тогтоолоор оруулсан өөрчлөлтийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр ХЗДХЯ-наас хөдөлгөөн хийж бүртгэсэн болно.

Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр энэхүү хуулийн шинэчилсэн найруулгад салбарын зохицуулалтын журам, баримт бичгүүдийг нийцүүлэх, давхардал, хийдлийг арилгах, шинээр батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байгаа билээ. Энэхүү арга хэмжээний хүрээнд ХХЗХ-ны 2023 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар Зөвшөөрлийн тухай” хуультай нийцүүлэн 2020 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл, шаардлага”-ын нэрийг хуульд нийцүүлэн “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний нөхцөл, шаардлага” гэж, нэр томъёолол, холбогдох заалтуудад өөрчлөлт оруулах шаардлага бүрдсэн болно. Иймээс ажлын хэсгээс энэхүү нөхцөл, шаардлагад өөрчлөлт оруулан батлах тухай асуудлыг боловсруулан Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 06 дугаар хуралдаанд холбогдох үндэслэл танилцуулга, хорооны хуралдааны тогтоолын төсөл, тогтоолын хавсралт баримт бичиг, эрх ашиг нь хөндөгдөж байгаа эрх бүхий хуулийн этгээдийн ирүүлсэн санал, саналын товчоо, уулзалт хэлэлцүүлгийн үр дүн, нөлөөллийн шинжилгээ зэрэг баримт бичгийг хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 52 тоот “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний нөхцөл, шаардлага”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолыг

батлав. Тогтоолоор, тус хорооны 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл, шаардлага”-ын нэр, 1.1, 1.2, 1.4, 1.7, 1.13, 1.14, 2.4, 3 дугаар зүйл, 3.1, 3.2, 3.3, 4.1.1, 4.2, 4.3, 4.4, 4.8, 5.1, 5.6, 5.9, 9.2, 9.3, 13.1.3, 13.2.1, 14, 15 дугаар зүйлд холбогдох өөрчлөлтүүдийг оруулан батлав. ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан нэмэлтээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2023 оны 01/925 албан тоотоор хүргүүлэв. Тус яамнаас Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4823 бүртгэлтэй 2020 оны 05 тоот тогтоолд оруулсан 2023 оны 52 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан өөрчлөлтийг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хөдөлгөөн хийж бүртгэснээр тогтоолыг хүчин төгөлдөр мөрдөж эхлэв.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар Монгол Улсын нутаг дэвсгэрт радио давтамж ашиглан харилцаа холбооны үйлчилгээ (яриа, дата, мессеж) эрхлэгчдийн харилцан холболтын чиглэлээр батлагдсан журам, зохицуулалтын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтын тайлан, дүгнэлттэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай ажлын хэсгийн тайланг сонсов. Уг асуудлаар Хорооны хуралдааны 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн “Шалгалтын тайлан, дүгнэлттэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр Тэмдэглэл гаргаж, холбогдох ажлын хэсэгт удирдамж чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгөхөөр тогтов. Тэмдэглэлд, Хяналт, шалгалтын дүгнэлтийг шалгалтад хамрагдсан Монгол Улсын нутаг дэвсгэрт радио давтамж ашиглан харилцаа холбооны үйлчилгээ (яриа, дата, мессеж) эрхлэгчдэд хүргүүлэх; Шалгалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгчдэд хяналт, шалгалтын хүрээнд шаардсан мэдээ, мэдээллийг гаргаж ирүүлэх, газар дээр нь очиж шалгах нөхцөл бололцоогоор хангах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх; Хугацаатай үүрэг, даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээний талаар судалж, санал боловсруулах; Тэмдэглэлийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай Хорооны хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгов.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийг шийдвэрлэсэн тайлангийн танилцуулга (Хорооны 2022 оны жилийн эцэс, 2023 оны 1 дүгээр улирал)-ыг сонсож, цаашид өргөдөл, гомдол хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх, дүн шинжилгээ хийж, мэдээллийн ил тод байдлыг хангах хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг холбогдох бүтцийн нэгжид даалгав.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, Дугаар ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 4 тогтоол, хавсралтын төслийг тус тус авч хэлэлцээд, тус хуралдаанаас 4 тогтоолыг хавсралтын хамт баталсан. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 53 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдэд 2 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь

заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 54 тоот тогтоолын хавсралтаар 13 хуулийн этгээдийн 16 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;

- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 55 тоот тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд харилцаа холбооны сүлжээний дугаарыг нэмж олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 56 тоот тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглалтын хугацааг сунгаж тус тус шийдвэрлэсэн.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-06-09